

Сайн нь дотоод үнэлэмжтэй болох тухай Ж.Э.Мүүрийн үзлийг шинжлэх нь

Б.Мөнхжавхлан, доктор (PhD), ахлах багш
МУИС, Философи шашин судлалын тэнхим

Б.Дагзмаа, доктор (PhD), профессор
МУИС, Философи шашин судлалын тэнхим

Хураангуй: Энэ өгүүлэлд Ж.Э.Мүүр, “сайн” гэдэг ойлголтыг тодорхойлох боломжгүйг тэрээр хэрхэн объектив байр суурины үүднээс харуулсныг “нээлттэй асуултын аргумент”-ын хүрээнд, “сайн” нь дотоод үнэлэмжтэй гэдгийг “органик нэгдэл”-ийн зарчмын үүднээс хэрхэн тайлбарласныг шинжилсэн. “Нээлттэй асуултын аргумент”-ын дагуу “сайн” гэж тодорхойлсон ямар ч тайлбар үргэлж “энэ үнэхээр сайн уу?” гэсэн асуулт тавьснаараа сайн хэмээх ойлголт болон хүний зориудын үйлдлийн үнэлэмжид анализ хийх арга зүй болж байдаг. Ийнхүү тодорхойлох боломжгүй гэсэн түүний тайлбар уг сайн хэмээх ойлголт дотоод үнэлэмжтэй болохыг харуулах үндэслэгээ болдог. Тэрээр сайн ба мууг тайлбарлах асуудалд нөхцлүүдийг шинжлэх нь онцгой ач холбогдолтой байдгийг үнэлэмжийн тухай үзэлтэйгээ уялдуулжээ. Мүүрийн философи ёс зүйн суурь ойлголт “сайн”-ыг тодорхойлохын оронд түүнийг энгийн, тодорхойлогдошгүй гэж үзэх аргачлалыг ашиглан, объектив байр суурь илэрхийлснээрээ ёс зүйн уламжлалт онолуудыг эргэн харах, ёс суртахууны бодит үндэслэлийг хайх өвөрмөц арга зүй болдгийг энд харуулав.

Түлхүүр үг: дотоод үнэлэмж, хэсэг ба бүхэл, органик нэгдлийн зарчим, сайн, ёс зүй, таашаал

Энэ өгүүлэлд Британийн философич Ж.Э.Мүүр (1873-1958)¹¹-ийн үзэл баримтлалд ёс зүй, үнэлэмжийн тухай санаа хэрхэн огтлолцдогийг философийнх нь үндсэн категориуд, үндэслэлээр авч үзэхийг эрмэлзсэн болно. Ингэхдээ “сайн” гэдэг ойлголтыг тодорхойлох боломжгүйг тэрээр хэрхэн объектив байр суурины үүднээс харуулсныг “нээлттэй асуултын аргумент”-ын тухай, “сайн” нь дотоод үнэлэмжтэй гэдгийг “органик нэгдэл”-ийн (нэгдэл гэдгийг бүхэл гэсэн нэршил, утгаар хэрэглэсэн) тухай тайлбараар шинжлэхийг зорив.

Сайн гэдгийг тодорхойлох боломжгүй тухайд буюу “нээлттэй асуултын аргумент боловсорсон нь”: Үзэл баримтлалын хувьд Мүүрийг реалист, аксиологи интуиционист, натуралист бус¹² үзэлтэн гэдэг. Тэрээр хэл, түүний илэрхийллийн талаар судлах явцдаа, бид энгийн хэл ашиглаж утга хийгээд үнэний асуултыг тавьж улмаар хэлж, ярьж буйгаа хэрхэн ашиглаж, ойлгож чадахаа мэддэг гэж байв. Бас ойлголтын агуулгыг анхан шатны ойлголтод задлах юм уу эсвэл өөр ойлголтуудад харьцуулан анализ хийдэг гэж тэрээр үзжээ. Ингээд анализын аргаа ёс зүйн сургаалынхаа цөм асуудал гэж тодорхойлсон “юу сайн бэ” гэх асуултад

¹¹ Жорж Эдуард Мүүр (1873-1958) Бертран Рассел, Людвиг Витгенштейн, Готлиб Фреге нарын хамт аналитик философи үндэслэгчдийн нэг юм. Тэрээр Кембрижийн их сургуульд профессороор ажиллаж байсан. Тухайн үеийнхээ Британийн алдартай сэтгүүл Оюун ухаан (Mind) сэтгүүлийг эрхэлж байв. Principia Ethica (1903), The Nature of Judgement (1899), The Refutation of Idealism (1903), The Conception of Intrinsic value (1922) бүтээлүүдийг бичсэн.

¹² Ж.Мүүр “сайн” гэдэг ёс зүйн ойлголтыг онцлон шинжлээд өмнөх үеийнхэн уг ойлголтыг натуралистаар, өөрөөр хэлбэл ямар нэг буян, жаргал, таашаал гэх мэт юмтай адилтган тодорхойлдог нь буруу хэмээн үнэлсэн юм. Учир нь эдгээр дурдсан зүйлс сайны үндэс дандаа байж чаддаггүй. “Сайн” гэдэг нь энгийн, задлан шинжлэх боломжгүй, натурал бус шинжтэй, тэрхүү натурал бус шинж нь анализ хийж болдог ямар нэгэн “тааламжтай эсвэл хүсүүштэй “натурал” шинж чанартай биш буюу априори, зайлшгүй, аналитик ойлголт гэжээ. Иймд түүний үзэл баримтлалыг натуралист бус гэдэг.

хариулт өгөхөд ашигласан байна. Тэрээр ёс суртахууны хэлний асуудлыг анхааран судалж ёс зүйн үндсэн ойлголт болох “сайн”-ны тухай тодорхойлолтоос философидолтоо эхлүүлсэн.

Мүүр “ёс зүйн зорилт нь юу хийвэл зохих вэ гэдэг асуултанд өгсөн хариултуудын аль нь зөв вэ гэдгийг батлах; хүний зан авир, үйлдлүүд ёс суртахуунлаг эсэх тухай бидний нотлон хэлсэн зүйлс ямар үндсэн дээр үнэн, эсвэл худал болдгийг тайлбарлахад оршино” гэж үзсэн юм. Үүнийгээ батлахдаа “ийм байгаа”-гаас “ийм байх ёстой”-г буюу хүний төлөв байдлын одоо байгаа баримтаас ёс суртахууныг тодорхойлж болохгүй гэсэн байна. Мүүр “сайн”, “муу” хэмээн үнэлгээ өгч байгаа хоёр үйлдлийг ялгаж үзэхийн өмнө эдгээр ойлголтын утгыг сайтар шинжлэх ёстой хэмээгээд “Ёс зүйн зарчмууд” номондоо ёс зүйн гол асуудал бол сайныг тодорхой үйлдэлтэй холбон тайлбарлах биш харин “сайн гэж юу вэ?” буюу “сайн” гэдэг ойлголтын утгыг хэрхэн тодорхойлох тухай юм гэжээ. Ёс суртахууны тухай Мүүрийн реалист үзэл нь түүний натуралист бус байдлаар сайн хэмээх ойлголтыг тодорхойлохтой холбоотой юм (Hurka, 2003). Ингэхдээ тэрээр “сайныг бид зөнгөөрөө мэддэг” гэж үзээд зөнгөөрөө мэдэх буюу “интуиц” нь тодорхой үйлдлүүдийн зөв эсвэл бурууг бус, зөвхөн өөрийн зорилго болох сайныг л илрүүлдэг. Тэгээд сайныг оюун ухаанаар биш, харин интуитив мэдрэмжээр ойлгох бололцоотой гэсэн дүгнэлтэнд тэрээр хүрсэн бөгөөд үүгээр нь түүнийг интуиционист гэдэг. Интуитив интроспекциэр бид түүний энгийн, бууруулж болшгүй (irreducible), натурал бус, танин мэдэхүйн утгыг ойлгодог хэмээгээд зөв гэдэг бол сайны төлөөх аливаа үйлдэл гэж Мүүр тодорхойлжээ. (L.Hart, 1971).

Натурал бус гэж үзсэн шалтгаан нь тэрээр сайныг зөвхөн эмпирик байдлаар тодорхойлох боломжгүй гэж үзсэнтэй холбоотой. “Сайн”-ыг байгалийн шинж чанараар тайлбарлах оролдлого нь ёс суртахууны мөн чанарыг буруугаар ойлгож байгаа хэрэг гэж үзсэн. Түүний үзсэнээр “сайн” бол бүрэлдэхүүн хэсэгт хуваан задалж, шинжилж болдоггүй ойлголт аж. Сайныг “шар” гэдэг ойлголттой харьцуулъя. Тэрээр “сайн” бол “шар” гэдгийн нэгэн адил энгийн ойлголт бөгөөд шар ямар вэ гэдгийг мэдэхгүй хүнд тайлбарлахад хэцүү шиг сайн гэдгийг тайлбарлах амаргүй гэжээ (Yesilkaya, 2022). Сайн гэгдэх бүх зүйл таашаал мэтийн байгалийн зүйлийг хэн ч авч чадна, гэхдээ л “яагаад сайн юм бэ” гэдэг асуудал үүсч таарна. Тэрээр сайн гэж алдаршсан ямар нэг зүйл “яагаад сайн юм бэ?” гэсэн асуултыг үргэлж дагуулдаг (Стоукес, 2013) гэжээ.

Түүнийхээр сайн гэж юу болох тухайд “сайн бол сайн” (G.E.Moore, 1922, p. 6), эсвэл, “сайн” нь тодорхойлогддоггүй гэх урам хугалам цорын ганц хариулт байж болох юм. “Сайн бол сайн” гэдэг томъёолол хэдийгээр давталт буюу тавтологи мөн боловч сайны тухай бусад тодорхойлолтоос эрсдэл багатай. Түүнийхээр “сайн” гэдэг нь “цор ганц, энгийн бодлын объектыг” илэрхийлдэг бөгөөд үүнийг тодорхойлох, задлан шинжлэх боломжгүй ажээ (Yesilkaya, 2022). Энэ санаагаа батлахын тулд тэрээр хоёр үндэслэл гаргасан. Эхнийх нь сайныг өөр объекттой адилтган тодорхойлох нь натуралист алдаанд хүргэнэ гэж үзсэн. Энэхүү алдаа нь ёс зүйн утга бүхий хэллэгүүдийг нэг бол сэтгэл зүйн хэллэг болгож, эсвэл мэдээ дамжуулах хэллэг болгон бууруулснаас үүддэг. Өөрөөр хэлбэл, “х бол сайн” гэсэн ёс зүйн хэллэг байх ёстой байсан зүйл хүмүүсийн хүсэл эрмэлзэл эсвэл тэдний үгсийн хэрэглээн дэх баримтын тухай хэллэг болж хувирдаг.

Хоёр дахь үндэслэгээг буюу *нээлттэй асуултын аргументыг* тэрээр дараах байдлаар гаргасан: “сайныг” тодорхойлох боломжтой гэж бодъё. Үр дүн нь ёс зүйн хэллэгийг ёс зүйн бус хэллэг болгохоос бүр дор буюу ёс зүйн хэллэг тавтологи болох эрсдэлтэй. Жишээлбэл, “сайн” бол “таашаал” мөн гэж тодорхойлъё. Ингэхээр “таашаал авах нь сайн” байх нь. Эндээс таашаал бол таашаал гэсэн тавтологи байна. Ийм дүгнэлтээс зайлсхийхийн тулд “сайн” гэдэг нь “таашаал” гэхээс өөр утгатай байх ёстой. Нэгэнт “сайн” бол натурал бус шинжтэй тул түүнийг ямар ч хамаагүй аргаар “сайн” гэж тодорхойлох эрмэлзэлэл нь натуралистик алдаанд (naturalistic fallacy) хүргэх аюултай. Энэ үндэслэгээг *“нээлттэй асуултын аргумент”* гэж нэрлэдэг, учир нь

“сайн”-ы тохирох ямар ч тодорхойлолтыг хэн ч санал болгосон тэр нь юу үнэхээр “сайн” гэдгийн тодорхойлолтыг хангах уу үгүй юу гэсэн нээлттэй асуулт ямагт байх болно. Нөгөөтэйгүүр "нээлттэй асуултын аргумент"-ын сайныг натурал шинжээр (таашаал, аз жаргал гэх мэт) тодорхойлох оролдлого нь тухайн шинж үнэхээр сайн эсэхийг үргэлж нээлттэй үлдээдэг юм. Энэ нь түүнийг “сайн” бол энгийн, задлан шинжилж болохгүй зүйл гэж дүгнэхэд хүргэсэн ажээ.

Тэгэхээр Мүүрийн үзсэнээр "сайн" бол юуны түрүүнд энгийн бөгөөд натурал бус чанартай, нөгөөтэйгүүр түүний боловсруулсан "нээлттэй асуултын аргумент" нь үүнийг бататгаж, "сайн"-ыг тодорхойлох аливаа санал болгосон тайлбарын хувьд "гэхдээ энэ үнэхээр сайн уу?" гэж асуух нь утга учиртай, нээлттэй асуулт хэвээр байна гэдгийг харуулдаг. Энэ бол "сайн" гэдэг нь аливаа тодорхой шинж чанартай түүнийг адилтгаж эсвэл түүний үнэлгээг бууруулах боломжгүйг илэрхийлэхийн зэрэгцээ түүний үзэл баримтлал объективист байр суурьтай гэдгийг харуулж байна. Ийнхүү “сайн”-ыг тодорхойлогдошгүй гэж үзсэн нь Мүүрийн цаашдын мета ёс зүйн үндэс болж өгдөг.

Бидний өгүүллийн дараагийн хэсэг Мүүрийн үзэл дэх үнэлэмжийн тухай онолын тухай асуудалд хандана. Мүүрийн өгүүлж буй “сайн”-ыг тодорхойлж болшгүй байгаа явдал бол яг өөрийг нь биш, сайн гэж нэрлэгддэг юм үзэгдэл болон тэдний шинж чанаруудыг л хэлж байдгаас үүддэг. Тэрээр сайн ба мууг тайлбарлах асуудалд нөхцлүүдийг шинжлэх нь онцгой ач холбогдолтой байдгийг үнэлэмжийн тухай үзэлтэйгээ уялдуулжээ. Түүний энэ санааг тодотгох дотоод үнэлэмжийн асуудалд шилжье.

“Сайн” нь дотоод үнэлэмжтэй буюу “органик нэгдэл” хэмээх зарчимд нийцэх нь: Ёс зүйд бид сайн муу, буян ба нүгэл, зөв, буруу гэх мэт нэр томъёог дотоод үнэлэмжийн үүднээс шинжилдэг. Хүмүүсийн ердийн ярианд сайн эсвэл муу гэж нэрлэх ямар зүйлс байх, тэдгээр нь ашиг сонирхол, сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлж, ашиг тус юм уу эсвэл хор хөнөөл учруулж байгааг үнэлэх явдал түгээмэл байдаг. Бид туршлага, үйл явдал, харилцаа улмаар бүхий л амьдралыг энэ утгаар сайн юм уу муу хэмээн үнэлж чадна. Дотоод үнэлэмжийн¹³ тухай ойлголт ёс зүйд чухал ач холбогдолтой гэдгийг тэрээр батлахыг эрмэлзжээ. “Ёс зүйн зарчмууд” номдоо Мүүр “сайн” хэмээх ойлголтыг ёс зүйн хувьд "нийтлэг бөгөөд өвөрмөц (common and peculiar) (G.E.Moore, 1922) гэж үзсэн бөгөөд түүнийг "дотоод үнэлэмж"-тэй гэсэн. Ямар нэг юмны дотоод үнэлэмж гэдэг бол "өөртөө байдаг" (in itself) эсвэл "өөрийнхөө төлөө" (for its own sake or as such) эсвэл "өөрийн мөн чанараараа" (in its own right) гэх мэт утгуудыг илэрхийлдэг. “Дотоод үнэлэмжийн тухай ойлголт” эссендээ Мүүр, үнэлэмжийн нэг төрөл “дотоод” уг чанартай гэх нь аливаа зүйлд тэр чанар байгаа эсэх, тэр зүйл түүнийг хэр зэрэг агуулж байгаа эсэх асуулт гагцхүү тухайн зүйлийн дотоод мөн чанараас хамаарна л гэсэн утгатай. (G.E.Moore, 1922)

Энэ тохиолдолд зарим философич үнэлэмжийн эх сурвалжийг голчлон авч үздэг бол зарим нь сэтгэл хөдлөл, хүсэлд "нийцтэй" юм уу "зохистой" (fittingness or appropriateness) гэсэн ойлголтыг хамтатгадаг. Мүүр үнэлэмжийн эх сурвалжийг онцолж үзэхдээ х-ийн дотоод үнэлэмж нь зөвхөн өөрийн мөн чанарынхаа ачаар байгаа үнэлэмж мөн, жишээ нь хэн нэгний таашаал авч буй байдал нь зөвхөн өөрийн мөн чанараараа үнэлэмжтэй байх нөхцөл дэх үнэлэмж байдаг.

Германы сэтгэгч Brentanoгийн үзсэнээр хэрвээ х зүйл тухайн хүнд хүсэл таашаал өгч чадахаар, онцгойлон үзэх тааламжтай байвал тэрхүү х нь дотоод үнэлэмжтэй (дотоод чанараараа сайн) байна гэж хэлж болох ажээ. Өөрөөр хэлбэл тухайн хүнд сэтгэлийн тааламж өгч байгаа х бусад хүнд бас хүсэл, тааламжийг төрүүлэх шинжийг агуулсан байж сая тэрхүү х дотоод үнэлэмжтэй болно гэсэн үг юм. Энэ үүднээс Brentanoгийн үзэл сэтгэл хөдлөлийн асуудлыг

¹³ Үнэлэмжийн онолд хэд хэдэн төрлийн үнэлэмжийг авч үздэгээс дотоод үнэлэмж хамгийн гол үнэлэмж бөгөөд судлаачид эцсийн үнэлэмж гэж нэрлэсэн нь байдаг. Дотоод үнэлэмж арга хэрэгслийн, уг чанарын, нөлөөлөгч гэсэн бусад үнэлэмжийн суурь болно.

онцолсон ч үүнийгээ ямар нэг объектоос хамаармал зүйл биш, харин өөрөө объектив, бие даасан шинжтэй гэж үзсэнээр Мүүрийн үзэлтэй ойр байдаг.

Мүүр цааш дотоод үнэлэмжтэй зүйлийг тоочин илэрхийлэхдээ ухамсар, сайхан амьдрал, мэдлэг, ухаарал, ёс суртахуун, эрхэм чанар, буянт үйлс, нөхөрлөл, бие биенээ хайрлах сэтгэл, сайхан, гоо зүйн туршлага, шударга ёс, өөрийгөө илэрхийлэхүй зэргийг нэрлэсэн аж. Жишээ нь, дотоод үнэлэмж урлагийн бүтээлийн сайхан гэх мэт зүйлд байх бөгөөд тэдгээрийн "дотоод мөн чанар" нь янз бүрийн хэсгүүдийн хоорондын харилцааны асуудлаас хамаардаг (өнгө, хэлбэрийн тодорхой зохицол). Ийм харилцаа нь урлагийн бүтээлийг онцгой, үзэгчдэд сэтгэл хөдлөл төрүүлдэг, төрөл жанраараа өвөрмөц бүтээл болгож байдаг ажээ. Энэ нь Мүүрийн боловсруулсан "органик нэгдлийн зарчим"-тай холбоотой бөгөөд тэрээр "Ёс зүйн зарчмууд" бүтээлдээ эл зарчмыг дотоод үнэлэмжийн асуудалд холбон тайлбарласан байна.

Ингэхдээ Мүүр "өөрийнхөө төлөө (for its own sake), өөрөөрөө байдаг (in-itself) гэсэн ойлголтуудын утгыг, тэдгээрийн үнэлэмж нь бүхэлдээ юм уу хэсэгчлэн "гадна" байдаг зүйлээс биш, харин "үнэлэмж бүхий өөрийнх нь дотоод шинж чанартай холбоотой" гэж үзсэн байна. Дотоод үнэлэмжийн тухай үзэл санаагаа бататгахын тулд тэрээр "тусгаарлах арга" (isolation method)-ын тухай авч үзсэн (Allen, 2004). Энэ нь ямар нэг юмны дотоод үнэлэмжийг бусад зүйлтэй харилцан хамааруулан тайлбарлахаас зайлсхийж, зөвхөн тухайн зүйлийн өөрийн мөн чанартай холбон ойлгохыг хэлнэ. Өөрөөр хэлбэл "ганцаар нь" оршин буйгаар төсөөлөх замаар, тухайн юмны мөн чанар үнэхээр ямар вэ гэдгийг мэдэх явдал юм. Энэ арга Мүүрийн объективист байр суурийг илэрхийлдэг.

Түүнийхээр үнэлэмжийн онолыг хөгжүүлэх зорилго бол тухайн юм аль ангилалд хамаарахыг тодорхойлох явдлыг онцолсон аж (Allen, 2004). Цаашилбал, анги тус бүрийн зүйл зарим нэг бүхлийн хэсэг болж үүсч болох ба эдгээр хэсгээс бүтсэн бүхэл нь эерэг юм уу сөрөг үнэлэмжтэй, эсвэл бүхэлдээ үнэлэмжгүй байх бололцоотой юм. Бүхэл нь энгийн хэсгүүдээс бүрддэг гэдэгт үндэслэн Мүүр органик нэгдлийн зарчмыг дэвшүүлсэн. Ингэхдээ бүхлийн үнэлэмж нь, үүнийхээ хэсгүүдийн үнэлэмжийн нийлбэртэй тэнцүү юу? гэсэн асуултыг тавьжээ. Мүүрийн үзлээр "ийм органик бүхэл зүйлийн үнэлэмж тогтмол харьцаатай байдаггүй (өөрөөр хэлбэл, заавал тэнцүү байхгүй) бөгөөд түүний хэсгүүдийн үнэлэмжийн энгийн нийлбэр байх албагүй" гэсэн. Мүүр "органик" гэсэн нэр томъёог зөвхөн энэ баримтыг илэрхийлж хэрэглэсэн юм. Гэхдээ "органик" гэдэг нэр томъёо нь хэсгийн үнэлэмж бүхлийн гишүүн болсноор ямар нэг байдлаар дээшилдэг гэсэн үг биш хэмээн түүний хэлснийг санах ёстой". (Allen, 2004). Өөрөөр хэлбэл, "органик" гэдэг нь хэсгүүдийн харилцан хамаарал бүхий үнэлэмжийг бүхэл системд харгалзан үзэхийг илэрхийлэх боловч, тухайн хэсгийн өөрийнх нь үнэлэмжийг сайжруулж байгаа гэсэн утга агуулаагүй байдаг. Ингэхээр дотоод үнэлэмжийн хувьд бүхлийн үнэлэмж нь түүний хэсгүүдийн (дотоод) утгуудын нийлбэртэй тэнцэх ёсгүй. Үүнийгээ тайлбарлаж тэрээр тодорхой нөхцлүүдийг тоочсон¹⁴. Мүүрийн үзэж буй "органик нэгдэл" нь бүхэл ба хэсгүүдийн

¹⁴ Органик нэгдлийн зарчим дараах зургаан нөхцлийг агуулдаг:

1. Хоёр сайн зүйл (хэсэг) нийлж, эдгээрийн тус тусын үнэлэмжийн нийлбэрээс илүү дотоод үнэлэмж бүхий бүхлийг бий болгох боломжтой
2. Нэг сайн зүйл, өөр нэг тодорхой үнэлэмжгүй (indifference) зүйлтэй нэгдэж, зөвхөн сайн зүйлийн үнэлэмжээсээ илүү үнэлэмжтэй бүхлийг үүсгэж болно.
3. Хоёр муу зүйл нийлж, тэдгээрийн сөрөг үнэлэмжийн нийлбэрээс илүү муу бүхлийг бий болгох боломжтой
4. Тодорхой үнэлэмж байхгүй хоёр зүйлээс, дотоод үнэлэмж бүхий эсвэл эерэг утгаараа муу бүхлийг үүсгэж болно.
5. Нэг муу үнэлэмжтэй зүйлд сайн бүхэл нэмэгдэхэд, бүхлийн эерэг үнэлэмж өсөх боломжтой.
6. Хоёр муу зүйл нийлж, эерэг үнэлэмжтэй бүхлийг үүсгэж болно.

хооронд шалтгаацсан хамаарал байхыг шаарддаггүй боловч бас үгүйсгэдэггүй (Allen, 2004). Түүнийхээр “бүхэл, хэсгийн харилцаа заавал шалтгаант холбоогоор холбогдох буюу зайлшгүй харилцаанд байдаггүй”. Хэрэв тэгж үзвэл органик биш болно.

Тэрбээр органик бүхлийн жишээнд сайхны таашаал, хүний бие, хайр, харгислал, энэрэх сэтгэл, зориг, орчлон ертөнц, юмсын төлөв байдлыг багтаан оруулсан бөгөөд органик гэж тооцогдож буй нэгдлүүд нь нарийн төвөгтэй бөгөөд органик бүхэл болж чадах хэсгүүдээс бүрдэнэ. Энэхүү үзлийн дагуу, дотоод үнэлэмжийн хувьд сайн байгаа нэг “хэсэг” нь “бүхэл”-ийнхээ дотоод үнэлэмжийг багасгаж, дотоод үнэлэмжээрээ муу байх нэг “хэсэг” байгаа нь тухайн “бүхэл”-ийн дотоод үнэлэмжийг нэмэгдүүлж болзошгүй байдаг.

Зарим философич дотоод үнэлэмжийн органик чанарыг хамгаалдаг. Тухайлбал Мүүрийн үзлээр, дотооддоо сайн чанар бүхий нэг хэсэг нь тухайн бүхлийнхээ дотоод үнэлэмжийг багасгах боломжтой байхад, дотооддоо муу чанар бүхий нэг хэсэг нь тухайн бүхлийнхээ дотоод үнэлэмжийг нэмэгдүүлэх боломжтой. Органик чанарыг хамгаалагчид, Митфройд (Mitfreude) буюу бусдын баяр хөөрт баярлах болон Шаденфройд (Schadenfreude) буюу бусдын зовлон зүдгүүрээс баярлах мэдрэмж, таашаал авах гэсэн ойлголтыг ашиглан үзэл санаагаа тайлбарладаг.

Жишээлбэл: Жонс Смитыг аз жаргалтай гэж буруу бодсон боловч үүнээсээ таашаал авдаг, харин Браун Грейг зовж байна гэж буруу бодсон боловч мөн үүнээсээ таашаал авдаг. Митфройдын жишээ болох Жонсын баяр хөөр нь Шаденфройдын жишээ болох Брауны баяр хөөрөөс илүү дотооддоо сайн чанартай мэт байна. Хоёулаа баяр хөөрийн илрэл боловч алинд нь ч дотооддоо муу чанар агуулагдаагүй байна. (Robert Audi, 1999; Zimmerman, 2015)

Энэ тохиолдолд бусдын баяр хөөрт баярлаж байгаа нь, бусдын зовлонгоос таашаал авахаас илүү дээр боловч тэдгээр нь хоёулаа таашаал авчирч буй нь үнэн, бүхэлдээ муу талтай биш байна.

Ингэхээр “бүхэл”-ийн үнэлэмж нь түүнийг бүрдүүлэгч “хэсэг”-үүдийн үнэлэмжийн "зөвхөн нийлбэр" биш юм. Тэгэхээр бүхэл доторх хэсгүүдийн дотоод үнэлэмж тухайн бүхэлд хэрхэн хувь нэмэр оруулж буйгаас хамаарч өөрчлөгдөж болно. Дахин өөр нэг жишээг авч, гоёмсог зургийг “бүхэл” гэе. Зургийг бүрдүүлж буй хэсгүүд (өнгө, хэлбэр, бүтэц гэх мэт) дангаараа дотоод үнэлэмжгүй байж болох ч тэдгээрийг урнаар зохиомжлон зургийг зурахад бүхэл нь дотоод үнэлэмжтэй болдог. Нөгөөтэйгүүр хоёр тусдаа сайн зүйл (жишээ нь, таашаал ба мэдлэг) нийлснээр заавал илүү үнэлэмжтэй бүхэл үүснэ гэдэг нь боломжгүй ажээ. Мүүрийн философид тэгэхээр "дотоод үнэлэмж" бол тухайн зүйлийнхээ мөн чанараас хамаардаг бөгөөд түүгээрээ үнэлэгддэг. Түүнээс гадна "органик нэгдэл"-ийн зарчим нь бүхэл ба түүний хэсгүүдийн үнэлэмжийн нийлбэр заавал тэнцэх албагүйг илэрхийлж байгаагаараа “бүхэл” зүйлийн үнэлэмжийн маш нарийн төвөгтэй онцлогийг харуулж байна.

Мүүр эдгээр дүгнэлтүүдийн эхний дөрөв нь илүү ойлгомжтой байж болох боловч, сүүлийн хоёр нь эргэлзээтэй санагдаж магадгүй гэж үздэг. Гэсэн хэдий ч, органик нэгдлийн зарчим ёсоор бүхлийн үнэлэмж нь түүний хэсгүүдийн үнэлэмжээс хамааралгүй гэж үздэг тул эдгээр сүүлийн хоёр дүгнэлт нь эхний дөрвөөс ач холбогдлоороо дутахгүй юм.

Энэхүү зарчимд цаашид авч үзэх ёстой зарим нөхцөл бий. Жишээлбэл, муу зүйл сайн бүхэлд нэмэгдэхэд эерэг үнэлэмжийг өсгөдөг бол, үүний адилаар сайн зүйл муу зүйлтэй нэгдэхэд тухайн муу зүйлийн сөрөг үнэлэмж бүхлийн сөрөг үнэлэмжийг ихэсгэх болно. Үүнтэй төстэйгээр, хоёр муу зүйл эерэг үнэлэмжтэй бүхэл үүсгэж болдог бол хоёр сайн зүйл муу эсвэл тодорхой үнэлэмжгүй бүхлийг үүсгэж болно. Эдгээр нь органик нэгдлийн зарчмын харилцаа юм (Allen, 2004).

Энэхүү өгүүлэлд Мүүр хэрхэн ёс зүйн категорид анализ хийх замаар үнэлэмжийн тухай үзэл баримтлалаа боловсруулсныг нээлттэй асуултын аргумент, органик нэгдлийн зарчим зэрэг асуудлын хүрээнд ийнхүү шинжиллээ. Мүүрийн философи ёс зүйн суурь ойлголт "сайн"-ыг тодорхойлохын оронд түүнийг энгийн, тодорхойлогдошгүй гэж үзэх аргачлалыг ашиглан, объектив байр суурийг илэрхийлж байна. "Нээлттэй асуултын аргумент"-ын дагуу "сайн" гэж тодорхойлсон ямар ч тайлбар үргэлж "энэ үнэхээр сайн уу?" гэх асуултад орон зай үлдээж байгаа нь бидний өгүүллийн үндсэн шугам болох сайн хэмээх ойлголт болон хүний зориудын үйлдлийн үнэлэмжид анализ хийхэд харгалзах чухал санаа болно. Түүний боловсруулсан "органик нэгдэл"-ийн зарчим, "тусгаарлах арга" дотоод үнэлэмжийн асуудлыг нарийвчлан шинжлэхэд чухал ач холбогдолтой юм. Ёс суртахууны нөхцөл байдлыг үнэлэхдээ харилцан хамаарал, уялдаа холбоог анхаарч үзэх шаардлагатайг онцолж байгаагаараа Мүүр натурализм, релятивизм, субъективизм зэрэг үзэл, баримтлалыг шүүмжилж, ёс зүйн уламжлалт онолуудыг эргэн харах, ёс суртахууны бодит үндэслэлийг хайх өвөрмөц арга зүй болж байгаа билээ.

Тэгэхээр бидний үзэж буйгаар Мүүрийн үзэл баримтлал ёс зүй, үнэлэмж уялдах өргөн агуулгатайн сацуу мэдлэгийн аливаа талбарт өнөө хэр үнэ цэнтэй, орчин үеийн ёс зүйн онол, практикт ач холбогдолтой хэвээр байгаа бөгөөд үнэлэмжийг эргэцүүлэх, нарийн төвөгтэй асуудлуудыг үнэлэх чухал онолын үндэс болж байна.

Ном зүй

1. Allen, J. (2004). G.E.Moore and the Principle of Organic Unity. The Journal of Value Inquiry 37, 329-339.
2. W.Ball, S. (1988). Reductionism in Ethics and Science: Contemporary look at G.E.Moore's open-question argument. American Philosophical Quarterly Vol 25, 197-213.
3. L.Hart, S. (1971). Axiology-Theory of Values. Philosophy and Phenomenological Research, 29-41.
4. Hurka, T. (2003). Moore in the Middle. Chicago Journals, 599-628.
5. Michael Zimmerman (2015). On the Nature, Existence and Significance of Organic Unities. Journal of Ethics and Social Philosophy. Vol 8, 1-25
6. G. E. Moore, (1922) The Conception of Intrinsic Value. Philosophical Studies
7. G.E.Moore. (1922). Principia Ethica. Cambridge University Press.
8. Orsi, F. (2015). Value theory. Bloomsbury Publishing Plc.
9. Robert Audi. (1999) The Cambridge Dictionary of Philosophy. 2nd Edition. Cambridge University Press
10. Yesilkaya, N. (2022). George Edward Moore on the Indefinability of Good. Entelekyia Logico-Metaphysical Review, 1-18.
11. <https://fair-use.org/g-e-moore/ethics/>

Analyzing J. E. Moore's View on the Intrinsic Value of Good

This article aims to explain Moore's concept of "good" in relation to the concept of intrinsic value. In doing so, it explores the salient points of his view, including the principle of organic unity and the open question argument. It elucidates what is considered good from the perspective of intuitionism and analyzes intrinsic value within the framework of metaethics.